



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/539

Хэрлэн сум

Дэвжээ тэмцээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдааны 10 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Бүс нутгаа мэдэж, нутаг орноороо бахархах хайрлан хамгаалах” үйл ажиллагааны хүрээнд “Эх түүхийн жимээр” дэвжээ тэмцээн зохион байгуулахад 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022
оны... дүгээр сарын...-ны
... дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зар, цлын тооцоо

№	Зардлын нэр	Тос	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	“Эх түүхийн жимээр” дэвжээ тэмцээн зохион байгуулах үйл ажиллагааны зардал	1	1,500,000	1,500,000
Нийт				1,500,000